



# Хорт хавдрын үзүүлэлт 2023

Улаанбаатар хот  
2024 он



#### Эрхэлсэн:

**Н. Эрдэнэхүү**, АУ-ны доктор, дэд профессор, Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирал



#### Тайланг боловсруулсан:

**Т. Ундармаа**, АУ магистр, Хорт хавдар эрт илрүүлгийн бүртгэл тандалтын албаны дарга, Эпидемиологич их эмч

**Ж.Уранболор**, АУ доктор, Хорт хавдар эрт илрүүлгийн бүртгэл тандалтын албаны Эпидемиологич их эмч

#### Тайланг эмхэтгэсэн:

**С. Эрдэнэчимэг**, Статистикч бага эмчийн тэргүүлэх зэрэгтэй, НЭМ докторант



#### Тайлантай холбоотой саналыг дараах хаягаар ирүүлнэ үү:

- [undarmaa@cancer-center.gov.mn](mailto:undarmaa@cancer-center.gov.mn)
- [uranbolor@cancer-center.gov.mn](mailto:uranbolor@cancer-center.gov.mn)
- [chimeg\\_s@cancer-center.gov.mn](mailto:chimeg_s@cancer-center.gov.mn)

## Товчилсон үгийн жагсаалт

ТТ- тохиолдлын тоо

НӨӨТ - насаар өвөрмөц өвчлөлийн түвшин

ӨТ- өвчлөлийн түвшин

ӨСТ- өвчлөлийн стандартчилсан түвшин

ХТ- Хуримтлагдсан түвшин

НӨНБТ - насаар өвөрмөц нас баралтын түвшин

НБТ-нас баралтын түвшин

НБСТ- нас баралтын стандартчилсан түвшин

МV- Морфологийн онош батлагдсан хувь

## ЕРӨНХИЙ АГУУЛГА

**Үзүүлэлт тооцсон аргачлал:** Хорт хавдрын өвчлөлийн түвшин, насаар өвөрмөц өвчлөлийн түвшинг (насны бүлэгт тооцсон өвчлөлийн түвшин) тооцохдоо тухайн жилийн тухайн насны бүлгийн дундаж хүн амын тоог хүйсээр ялган тооцооллоо.

**Өвчлөлийн түвшин:** 100 000 хүн ам тутамд ноогдох тохиолдлын тоо бөгөөд энэхүү үзүүлэлтийг тооцохдоо хорт хавдрын өвчлөлийн нийт шинэ тохиолдлын тоог нийт хүн амд харьцуулна.

**Насаар өвөрмөц өвчлөлийн түвшин:** Тухайн насны бүлгийн 100 000 хүн ам тутамд ноогдох тохиолдлын тоо бөгөөд энэхүү үзүүлэлтийг тооцохдоо 5 насаар бүлэглэсэн насны бүлэг дэх шинэ тохиолдлын тоог тухайн насны бүлгийн хүн амын тоонд харьцуулна.

**Өвчлөлийн стандартчилсан түвшин:** Дэлхийн стандарт хүн амд харьцуулан гаргасан 100 000 хүн амд ноогдох тохиолдлын тоо бөгөөд насаар өвөрмөц өвчлөлийн түвшинг тухайн насны бүлгийн дэлхийн стандарт хүн ам (Sega standart population)-ын тоонд харьцуулсан харьцааны нийлбэрээр илэрхийлэгддэг ба өөр өөр газар нутгийн хүн амын өвчлөл эсвэл өөр цаг хугацааны өвчлөлийг хооронд нь харьцуулахад ашиглана.

**Хорт хавдрын шалтгаант нас баралтын үзүүлэлт:** Насаар өвөрмөц нас баралтын түвшин, нас баралтын түвшин, нас баралтын стандартчилсан түвшин өвчлөл тооцсон аргачлалтай адилаар тооцно.

Хорт хавдрын үндсэн үзүүлэлтийг 2023 оны дундаж хүн амд, хорт хавдрын мэдээний сангийн чанарын шалгуур үзүүлэлтүүдийг олон улсад тооцон гаргадаг зарим чанарын шалгуур үзүүлэлтийг ашиглан гаргалаа.

## Агуулга

<b>ХОРТ ХАВДРЫН БҮРТГЭЛИЙН ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ</b>	<b>5</b>
Хорт хавдрын өвчлөл нас баралтын хураангуй, 2023 он	10
<b>Бүлэг 1. ДЭЛХИЙ ДАХИНД ХОРТ ХАВДРЫН ӨВЧЛӨЛ, НАС БАРАЛТЫН БАЙДАЛ</b>	<b>12</b>
1.1 Элэгний хорт хавдар:	14
1.2 Ходоодны хорт хавдар:	15
1.3 Уушгины хорт хавдар:	16
1.4 Улаанхоолойн хорт хавдар:	17
1.5 Бүдүүн шулуун гэдэсний хорт хавдар:	18
1.6 Умайн хүзүү, хөхний хавдар:	19
1.7 Нойр булчирхайн хорт хавдар:	20
1.8 Хүүхдийн хорт хавдар:	21
<b>Бүлэг 2. ХОРТ ХАВДРЫН ӨВЧЛӨЛ, 2023 ОН</b>	<b>22</b>
2.1 Хорт хавдрын өвчлөл, бүтэц	23
2.2 Хорт хавдрын өвчлөлийн үндсэн үзүүлэлт	24
2.3 Хорт хавдрын өвчлөл, TNM үе шатаар	27
2.4 Хорт хавдрын өвчлөлийн түвшин, аймгуудаар	28
2.5 Зонхилох байрлалын хорт хавдар	29
<b>Бүлэг 3. ХОРТ ХАВДРЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ</b>	<b>35</b>
3.1 Хорт хавдрын нас баралтын бүтэц	36
3.2 Хорт хавдрын нас баралтын үндсэн үзүүлэлтүүд	37
3.3 Хорт хавдрын нас баралтын түвшин, аймгуудаар	38
3.4 Зонхилон тохиолдсон хавдрын шалтгаант нас баралт	39
<b>Бүлэг 4. ХҮҮХДИЙН ХОРТ ХАВДРЫН ӨВЧЛӨЛ, НАС БАРАЛТ</b>	<b>44</b>
4.1 Хүүхдийн хорт хавдрын үзүүлэлтүүд	45
<b>Бүлэг 5. ХОРТ ХАВДРЫН ХЯНАЛТЫН ТУХАЙ</b>	<b>48</b>

# ХОРТ ХАВДРЫН БҮРТГЭЛИЙН ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ




## ХОРТ ХАВДРЫН БҮРТГЭЛИЙН ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

Хорт хавдар нь дэлхий дахинаа түүний дотор манай оронд ч өсөн нэмэгдэх хандлагатай, Монгол улсын хүн амын нас баралтын 2 дах шалтгаан болсон хэвээр байна. Хорт хавдраас сэргийлэх, эрт илрүүлэх, хянах ажлыг эрчимжүүлэх, оновчтой болгох нотолгоонд тулгуурласан бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд хорт хавдрын бүртгэлийн мэдээний эх сурвалжийн чанар, үнэн зөв, бүрэн байдал зэргээс ихээхэн хамаарна. Иймд хорт хавдрын мэдээ, тайлагналт нь хорт хавдрын эсрэг бүхий л арга хэмжээг төлөвлөх, судалгааны ажлын нотолгоотой суурь эх сурвалж болох юм. Монгол улсын 2023 оны хүн амын суваргын 32.2 хувийг 15-аас доош насныхан, 65.3 хувийг 15-69 насныхан, 2.5 хувийг 70-аас дээш насныхан бүрдүүлж байна (Зураг 1).

### Мэдээний эх сурвалж:

Монгол улсад хорт хавдрын хууль эрх зүйн орчин нь ЭМСайдын 2013 оны 450 тоот тушаал, 2014 оны ЭМСайдын 431 тоот, 2019 оны ЭМСайдын А/611 тоот тушаалыг тус тус мөрдлөг болгон ажиллаж байна.

Зураг 1. Хүн амын нас хүйсийн суварга 2023



Хорт хавдрын мэдээний эх сурвалж байгууллагад Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Аймгийн нэгдсэн эмнэлэг (21), Улаанбаатар хотын дүүргийн эрүүл мэндийн төв (9), зарим төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг төвүүд, Сонгодо, Intermed, Сөүл эмнэлгүүд дийлэнх хувийг эзэлж байна. Хорт хавдрын бүртгэл хорт хавдрын шинэ тохиолдол, нас баралтын талаарх мэдээг бүрэн гүйцэт, үнэн зөв, цаг хугацаанд нь, харьцуулагдахуйц байдлаар бүртгэх зорилготой (Зураг 2 Хүснэгт 1). Хорт хавдрын шинэ тохиолдлын мэдээг “Хорт хавдрыг мэдээлэх хуудас-АМ-5” маягтаар (овог нэр, хаяг, хорт хавдар эрхтэний байрлал, морфологи онош, үе шат TNM ангиллаар, хийгдсэн эмчилгээ гм), Хорт хавдрын шалтгаант нас баралтын мэдээг “Нас баралтын гэрчилгээ АМ-7” маягтыг үндэслэн (овог нэр, регистрийн дугаар, онош, оношлогдсон оношийн дагуу хяналтын мэдээний санд тулгалт хийх) үндсэн мэдээний санг бүрдүүлж байна.

Хорт хавдрын бүртгэл нь үндэсний хэмжээнд тохиолдож буй хорт хавдрын шинэ тохиолдол, нас баралтыг бүрэн гүйцэт, цаг хугацаанд нь, бодитой, харьцуулагдахуйц байдлаар бүртгэн авах зорилготой.

(1) Бүрэн гүйцэт: Бүртгэлийн бүрэн гүйцэт чанар гэдэг нь тухайн хамрах хүрээний хүн амд тохиолдсон хорт хавдрын тохиолдлыг бүгдийг бүртгэхийг хэлнэ. Энэ чанарыг дараах үзүүлэлтүүдээр үнэлнэ. Үүнд:

### Нас баралт/тохиолдол харьцаа- M/I ratio

Нас баралт/тохиолдол харьцаа нь бүрэн гүйцэд байгааг илэрхийлэх чухал үзүүлэлт бөгөөд тухайн газар нутагт цаг хугацаанд бүртгэгдсэн хорт хавдрын нас баралт ба шинэ

тохиолдлын харьцаа юм. Энэ үзүүлэлтийг зөв тооцох нь шинээр оношлогдсон хорт хавдар, нас баралт (1-амьд үлдэх магадлал)-ыг илэрхийлдэг.

### **(2) Насаар өвөрмөц өвчлөлийн муруй**

Өвчлөлийн насаар өвөрмөц муруйг тооцох шаардлагатай чухал үзүүлэлт бөгөөд ихэнх хучуур эдийн гаралтай хавдрууд нас ахих тусам нэмэгддэг.

#### (2) Бодитой

Бодитой байдал нь хорт хавдрын бүртгэлийн мэдээллийн чанарыг үнэлэх чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Энэ нь зорилтот бүлгийн хүн амд тохиолдож буй хорт хавдрын бүх тохиолдлыг бүртгэлийн мэдээллийн санд оруулсан хэмжээгээр тодорхойлогддог. Тиймээс бүртгэгдсэн тохиолдлын бодит байдал нь мэдээллийн эх сурвалжийн үнэн зөв эсэх, бүртгэлийн мэдээллийн санд энэ мэдээллийг оруулах, кодлох, хувиргах бүртгэх ур чадварыг илэрхийлнэ.

Энэ чанарыг дараах үзүүлэлтүүдээр үнэлнэ. Үүнд:

### **(1) Микроскопиор баталгаажуулсан-MV**

Микроскопиор баталгаажуулсан хувь гэдэг нь бүртгэгдсэн хорт хавдрын нийт тоонд морфологиор баталгаажсан тохиолдлын эзлэх хувь юм. Энэ нь бодитой чанарын чухал үзүүлэлтийн нэг боловч гистологи, цитологи/гематологийн шинжилгээгээр оношлогдсон тохиолдол маш өндөр хувьтай байгаа нь эмгэг судлалын лабораторид хэт найдаж, өөр шинжилгээгээр оношлогдсон тохиолдлуудыг олж чадахгүй байгааг илтгэдэг.

### **(2) Нас баралтын гэрчилгээгээр оношлогдсон (DCO)**

Нас баралтын гэрчилгээнд үндэслэн тохиолдлыг бүртгэхийг хэлнэ. Нас баралтын гэрчилгээгээр оношлогдсон хувь нь 15-20% байвал зохино гэж үздэг.

### **(3) Хавдрын анхдагч байрлал тодорхойгүй (PSU)**

Нийт оношлогдсон хавдрын дотор хавдрын анхдагч байрлал тодорхойгүй тохиолдлын эзлэх хувь хэмжээ. Энэ үзүүлэлт 10% ба түүнээс дээш байх нь оношлогооны чанар сул байгааг илтгэнэ.


### **(4) Хавдрын тохиолдлын нас тодорхойгүй (Age UNK)**

Нийт оношлогдсон хавдрын тохиолдлын дотор хавдрын нас тодорхойгүй тохиолдлын эзлэх хувь хэмжээ. Энэ үзүүлэлт нь хавдрыг бүртгэн оруулах чанарыг хэмжинэ.

Хорт хавдрын шинэ тохиолдлын мэдээг “Хорт хавдрыг мэдээлэх хуудас-AM-5”-д үндэслэн (овог нэр, хаяг, хорт хавдар эрхтэний байрлал, морфологи онош, үе шат TNM ангиллаар, хийгдсэн эмчилгээ) бүртгэж мэдээллийг баяжуулан ажилладаг. Хорт хавдрын шалтгаант нас баралтын мэдээг нас баралтын гэрчилгээ (Нас баралтын гэрчилгээ AM-7)-нд үндэслэн (овог нэр, регистрийн дугаар, оношийг хяналтын мэдээний санд тулгалт хийн) бүртгэн авч тухайн жилийн хяналтын бааз мэдээллээс хасаж тооцдог.

Зураг 2-д 2020-2023 онд бүртгэгдсэн хорт хавдрын тохиолдлын тоог он оноор нь үзүүлсэн бөгөөд энэ хугацаанд Монгол улсын хэмжээнд сүүлийн 4 жилийн хугацаанд бүртгэгдсэн хорт хавдрын бүтцэд мэдэгдэхүйц өөрчлөлт ажиглагдахгүй байна.

Зураг 2. Бүртгэгдсэн хорт хавдрын тохиолдлын тоо 2020-2023





## ХОРТ ХАВДРЫН БҮРТГЭЛИЙН ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

### Хүснэгт 1. Хорт хавдрын морфологиор оношлогдсон байдал 2020-2023

Хавдрын байрлал ICD-10	2020 он			2021 он			2022 он			2023 он		
	N	M	MV%	N	M	MV%	N	M	MV%	N	M	MV%
Элэг C22	2183	511	23.4	1956	422	21.6	2286	497	21.7	2373	794	33.5
Ходоод C16	1118	724	64.8	963	565	58.7	1181	591	50.0	1259	757	60.1
Уушиг C34	507	196	38.7	446	171	38.3	521	142	27.3	473	183	38.7
Улаан хоолой C15	312	164	52.6	338	170	50.3	342	138	40.4	357	170	47.6
Умайн хүзүү C53	480	384	80.0	312	253	81.1	318	229	72.0	425	335	78.8
Хөх C50	244	205	84.0	278	214	77.0	283	205	72.4	344	256	74.4
Бүдүүн шулуун гэдэс C18-21	262	175	66.8	278	177	63.7	306	167	54.6	322	207	64.3
Бусад	1596	853	53.4	1410	701	49.7	1648	737	44.7	1691	912	53.9
<b>Нийт</b>	<b>6702</b>	<b>3212</b>	<b>47.9</b>	<b>5981</b>	<b>2673</b>	<b>44.7</b>	<b>6885</b>	<b>2706</b>	<b>39.3</b>	<b>7244</b>	<b>3614</b>	<b>49.9</b>

N-тохиолдлын тоо    M-Морфологиор оношлогдсон тохиолдлын тоо

2013 оноос морфологийн төлвийг Өвчний Олон Улсын Ангилал - Хавдар Судлал гуравдугаарыг ашиглан тоотлож байна. Шинэ тохиолдлын морфологиоор оношлогдсон хувь нь дунджаар 48-53 хувьтай байна.

Элэгний хорт хавдар хамгийн бага буюу морфологиор оношлогдсон хувь (23-36%), уушгины хорт хавдар (27-38%)-тай удаалж байна. Хөх, умайн хүзүүний хавдрын морфологиор оношлогдсон хувь хамгийн өндөр буюу 72-85%-тай байна (Хүснэгт 1).

### Хүснэгт 2. Хорт хавдрын байрлал тодорхойгүй, нас баралтын гэрчилгээгээр оношлогдсон байдал 2020-2023

Хугацаа	Шинэ тохиолдлын тоо	Анхдагч байрлал тодорхойгүй	PSU%	Нас баралтын гэрчилгээгээр оношлогдсон	DCO%
<b>2020</b>	6702	16	0.2%	565	8.4%
<b>2021</b>	5981	0	0%	600	10%
<b>2022</b>	6885	0	0%	789	11%
<b>2023</b>	7244	12	0.2%	355	5%

Шинээр бүртгэгдсэн хорт хавдрын тохиолдолын анхдагч байрлалыг заавал тодорхойлдог бөгөөд хорт хавдрын үндэсний бүртгэлийн хувьд анхдагч байрлал тодорхойгүй тохиолдол байхгүй, нас баралтын гэрчилгээгээр оношлогдсон тохиолдол дунджаар 5-11 хувьтай байна (Хүснэгт 2).




## Хорт хавдрын өвчлөл нас баралтын хураангуй, 2023 он

- Олон улсын хавдрын судалгааны агентлагийн статистик мэдээллээр 2022 онд 20 сая гаруй хүн хорт хавдраад өвдөж, 9.7 сая хүн хорт хавдрын шалтгааны улмаас нас баржээ. Зонхилох байрлалын хорт хавдрын өвчлөлд уушиг, хөх, бүдүүн шулуун гэдэс, түрүү булчирхай, ходоодны хорт хавдрууд байгаа бол уушиг, бүдүүн шулуун гэдэс, элэг, хөх, ходоодны хавдруудын шалтгаант нас баралт зонхилон тохиолджээ.
- Монгол улс хорт хавдрын өвчлөлийн түвшингээр (ASR 235.8) дэлхийд 45-р байранд, хавдрын шалтгаант нас баралтын түвшингээр (ASMR 181.5) дэлхийд 1-р байранд эрэмбэлэгдэж байна.
- Монгол улс элэг, ходоодны хорт хавдрын өвчлөл, нас баралтын түвшингээр дэлхийд 1-р байранд, улаан хоолойн өвчлөл нас баралтын түвшингээр дэлхийд 3-р байранд эрэмбэлэгдэж байна.
- Монгол улсын хүн амын дунд 2023 онд 7244 хорт хавдрын шинэ өвчлөл бүртгэгдсэн байна. Зонхилох байрлалын хорт хавдрын өвчлөлийн бүтцэд элэгний хорт хавдар 32.8%, ходоодны хорт хавдар 17.4%, уушиг гуурсан хоолой хорт хавдар 6.5%, умайн хүзүүний хорт хавдар 5.9%, улаан хоолойн хорт хавдар 4.9%-ийг эзэлж буй бөгөөд эдгээр нь нийт 2023 онд бүртгэгдсэн хорт хавдрын 67.5 хувийг эзэлж байна.
- Бүртгэгдсэн хавдрын тооны хувьд эрэгтэйчүүдийн дунд элэг, ходоод, уушиг гуурсан хоолойн, улаанхоолой, бөөрний хавдар, эмэгтэйчүүдийн дунд элэг, умайн хүзүү, ходоод, хөх, бүдүүн шулуун гэдэсний хорт хавдар зонхилон эхний 5 байрлалд тохиолдож байна.
- 2023 онд хорт хавдрын өвчлөлийн улсын дундаж түвшин 214.1 тохиолдол, хүйсээр харьцуулахад эрэгтэйчүүдэд (ӨТ 224.7) байгаа нь эмэгтэйчүүдийнхээс (ӨТ 203.9) өндөр байна.
- Элэгний хорт хавдрын өвчлөлийн түвшин аль ч хүйсэнд хамгийн өндөр буюу 100 000 эрэгтэй хүн амд 80.3 тохиолдол, эмэгтэй хүн амд 60.3 тохиолдол, харин ходоодны хорт хавдар 100 000 эрэгтэй хүн амд 51.6 тохиолдол, эмэгтэй хүн амд 23.3 тохиолдол ногдон удаалж байна.
- 75 хүртэлх насны нийт хүн амын хорт хавдарт өртөх эрсдэл 28.4% (Эрэгтэй 35.6%, эмэгтэй 23.4%) буюу 3 эрэгтэй тутмын 1, 5 эмэгтэй тутмын 1 нь хорт хавдарт өртөж байна.
- Хорт хавдрын өвчлөлийн түвшинг насны бүлгээр авч үзвэл нас ахих тусам хорт хавдрын өвчлөлийн түвшин тасралтгүй нэмэгдэн 75-аас дээш насны нийт хүн амд хамгийн өндөр буюу 100 000 хүн амд 2143.4, 100 000 эрэгтэй хүн амд 2671, 100 000 эмэгтэй хүн амд 1844 тохиолдол байна.
- 2023 онд бүртгэгдсэн зонхилох 10 байрлалын хавдрын 34.6% нь эрт үе шатандаа, 65.4% нь хожуу үе шатандаа оношлогджээ.
- 2023 онд хорт хавдрын өвчлөлийн улсын дундаж түвшин 214.1 байсан бөгөөд Булган аймаг өвчлөлийн түвшингээрээ хамгийн өндөр (379.8), Баян-Өлгий аймаг хамгийн бага (154.1), 15 аймаг улсын дунджаас өндөр, 6 аймаг, Улаанбаатар хот улсын дунджаас бага үзүүлэлттэй байна.
- Бүсүүдийн хорт хавдрын өвчлөлийг улсын дундажтай харьцуулахад баруун, зүүн, хангайн, төвийн бүсүүд улсын дунджаас өндөр, Улаанбаатар хот бага үзүүлэлттэй байна.
- Зонхилох байрлалын хавдруудаас элэгний хорт хавдар Зүүн бүс, Булган аймагт өндөр; ходоодны хорт хавдар Баруун бүс, Увс аймагт өндөр; уушгины хорт хавдар Зүүн

- бүс, Булган аймагт өндөр; улаан хоолойн хорт хавдар Баруун бүс, Увс аймагт өндөр; бүдүүн шулуун гэдэсний хорт хавдар Зүүн ба Төвийн бүс, Говьсүмбэр аймагт өндөр; умайн хүзүүний хорт хавдар Төвийн бүс, Булган аймагт өндөр; хөхний хорт хавдар Зүүн бүс, Дорноговь аймагт өндөр байна.
14. Хорт хавдрын шалтгаант нас баралт 2023 онд 4556 бүртгэгдсэн нь өмнөх оноос 8 тохиолдлоор нэмэгджээ.
15. 2023 онд зонхилох байрлалын хорт хавдрын шалтгаант нас баралтын бүтцэд элэгний хорт хавдар 37.6%, ходоодны хорт хавдар 16.4%, уушиг гуурсан хоолой хорт хавдар 8.7%, улаан хоолой 6%, бүдүүн шулуун гэдэс 4.5% буюу нийт хорт хавдрын шалтгаант нас баралтын 73.2 хувийг дээрх байрлалын хорт хавдрууд эзэлж байна.
16. Эрэгтэйчүүдийн дунд элэг, ходоод, уушиг гуурсан хоолойн, улаанхоолой, нойр булчирхайн хорт хавдар, эмэгтэйчүүдийн дунд элэг, ходоод, умайн хүзүү, улаан хоолойн, бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын шалтгаант нас баралт зонхилж байна.
17. Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин нийт хүн амд 134.7 (эрэгтэй 100 000 хүн амд 154.3 тохиолдол, эмэгтэй 100 000 хүн амд 115.6 тохиолдол), аль ч хүйсийн 100 000 хүн амд элэг, ходоодны хорт хавдрын нас баралт өндөр байна.
18. Хорт хавдрын нас баралтын түвшинг насны бүлгээр авч үзвэл нас ахих тусам хорт хавдрын нас баралтын түвшин тасралтгүй нэмэгдэн 75-аас дээш насныханд хамгийн өндөр буюу 100 000 хүн амд 2123; 100 000 эрэгтэй хүн амд 2538, 100 000 эмэгтэй хүн амд 1889 тохиолдол ногдож байна.
19. 2023 онд хорт хавдрын нас баралтын улсын дундаж түвшин 134.7 байсан бөгөөд Увс аймаг нас баралтын түвшингээрээ хамгийн өндөр (187.7), Говьсүмбэр аймаг хамгийн бага (99.6), 15 аймаг улсын дунджаас өндөр, 6 аймаг, Улаанбаатар хот улсын дунджаас бага үзүүлэлттэй байна.
20. Бүсүүдийн хорт хавдрын нас баралтыг улсын дундажтай харьцуулахад баруун, зүүн, хангайн, төвийн бүсүүд улсын дунджаас өндөр, Улаанбаатар хот бага үзүүлэлттэй байна.
21. Зонхилох байрлалын хавдруудаас элэгний хорт хавдрын шалтгаант нас баралт Зүүн бүс, Дорнод аймагт өндөр; ходоодны хорт хавдрын шалтгаант нас баралт Баруун бүс, Увс аймагт өндөр; уушгины хорт хавдар Зүүн бүс, Дорноговь аймагт өндөр; улаан хоолойн хорт хавдар Баруун бүс, Увс аймагт өндөр; бүдүүн шулуун гэдэсний хорт хавдар Зүүн бүс, Хэнтий аймагт өндөр; нойр булчирхайн хорт хавдар Баруун бүс, Говь-Алтай аймагт өндөр байна.
22. 2023 онд шинээр оношлогдсон хорт хавдартай хүмүүсийн 29% нь 1 жил хүрэхгүй хугацаанд нас баржээ.
23. Монгол улсад 2023 онд 0-19 насны 125 хүүхдэд хорт хавдрын шинэ тохиолдол бүртгэгдсэн бол хорт хавдрын шалтгааны улмаас 0-19 насны 63 хүүхэд эндсэн байна.
24. 0-19 насны хүүхдийн хорт хавдрын өвчлөлийн бүтцэд лейкеми 45%, тархи мэдрэлийн 20%, яс мөгөөрс, зөөлөн эдийн 4%, бөөр 4%, ходжкины бус лимфома 3%-ийг эзэлж байна.
25. 0-19 насны хүүхдийн хорт хавдрын өвчлөл, нас баралтын түвшинд лейкеми 45%, тархи мэдрэлийн хавдар тэргүүлж байна.
26. Монгол улсад 2023 оны жилийн эцэст хорт хавдар оноштой 28855 хүн амьдарч байгаагийн 547 (нийт хяналтын 1.9 хувь) 0-19 насны хүүхэд байна. Хорт хавдрын хяналтад байгаа хүмүүсийн 49 хувь нь 5 ба түүнээс дээш жил амьдарч байна.

## Бүлэг 1. ДЭЛХИЙ ДАХИНД ХОРТ ХАВДРЫН ӨВЧЛӨЛ, НАС БАРАЛТЫН БАЙДАЛ




## Бүлэг 1. ДЭЛХИЙ ДАХИНД ХОРТ ХАВДРЫН ӨВЧЛӨЛ, НАС БАРАЛТЫН БАЙДАЛ

2022 оны байдлаар Олон улсын хавдрын судалгааны агентлаг (IARC)-ын мэдээгээр Монгол улс хорт хавдрын өвчлөлийн түвшингээр дэлхийн 185 орноос 45 дугаарт эрэмбэлэгдэж байна. Монгол улсад бүртгэгдсэн нийт хорт хавдрын тохиолдлын тоог дэлхийн стандарт хүн амтай харьцуулан тооцоход 100 000 хүн амд 235.8 тохиолдол ногдож байгаа ба энэ үзүүлэлт эрэгтэйчүүдэд 280.4, эмэгтэйчүүдэд 202.0 байна (Зураг 3). Монгол улс хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин 100 000 хүн амд 181.5 тохиолдол (эрэгтэйчүүдэд 227.5, эмэгтэйчүүдэд 145.5) ногдож дэлхийн 185 орноос 1 дүгээрт эрэмбэлэгдэж байна (Зураг 4).

**Зураг 3. Хорт хавдрын өвчлөлийн стандартчилсан түвшин, харьцуулалт**

Өвчлөлийн түвшин (дэлхий, Ази номхон далайн баруун бүс, зүүн ази)


Өвчлөлийн түвшин (дэлхий, Ази номхон далайн баруун бүс, зүүн ази), хүйсээр



**Зураг 4. Хорт хавдрын нас баралтын стандартчилсан түвшин, харьцуулалт**

Age standardized mortality rate (World, WPRO, Eastern Asia, Mongolia) both sex combined

Age standardized mortality rate (World, WPRO, Eastern Asia, Mongolia) by sex



Олон улсын хавдрын судалгааны агентлаг (IARC)-ын 2022 оны үзүүлэлтээс Монгол улсын хорт хавдрын өвчлөл, нас баралтын зонхилон тохиолдох 5 байрлалаар, хүүхдийн хорт хавдрын өвчлөл, нас баралтыг Зүүн азийн бүс, Номхон далайн баруун эргийн бүс, Дэлхийн дундажтай тус тус харьцууллаа (Зураг 4).




## 1.1 Элэгний хорт хавдар:


Монгол улс элэгний хорт хавдрын өвчлөлийн түвшингээр дэлхийн 185 орноос 1 дүгээрт эрэмбэлэгдэж дэлхийн дунджаас 11 дахин, Ази номхон далайн баруун бүсийн орнуудын дунджаас 6 дахин, зүүн азийн орнуудын дунджаас 6 дахин өндөр байна.

Хүйсээр ялган харвал эрэгтэй хүйсийн элэгний хорт хавдрын өвчлөл дэлхийн дунджаас 9 дахин, эмэгтэй хүйсийн элэгний хорт хавдрын өвчлөл 17 дахин өндөр байна (Зураг 5). Элэгний хорт хавдрын нас баралтын түвшингээр дэлхийн 185 орноос 1-рт эрэмбэлэгдэж, дэлхийн дунджаас 11 дахин, Ази номхон далайн баруун бүсийн орнууд ба зүүн азийн орнуудын дунджаас 6 дахин өндөр байна (Зураг 5).

Зураг 5. Элэгний хорт хавдрын өвчлөлийн стандартчилсан түвшин, харьцуулалт



Зураг 6. Элэгний хорт хавдрын нас баралтын стандартчилсан түвшин, харьцуулалт






## 1.2 Ходоодны хорт хавдар:


Монгол улс ходоодны хорт хавдрын өвчлөлийн түвшингээр дэлхийн 185 орноос 1 дүгээрт эрэмбэлэгдэж дэлхийн дунджаас 4 дахин, Ази номхон далайн баруун бүсийн орнуудын дунджаас 2 дахин, зүүн азийн орнуудын дунджаас 2 дахин өндөр байна. Хүйсээр ялган харвал эрэгтэй хүйсийн ходоодны хорт хавдрын өвчлөлөөр дэлхийн дунджаас 4 дахин, эмэгтэй хүйсийн ходоодны хорт хавдрын өвчлөлөөр 3.6 дахин өндөр байна (Зураг 7).

Ходоодны хорт хавдрын нас баралтын түвшингээр дэлхийн 185 орноос 1-рт эрэмбэлэгдэж байгаа ба дэлхийн дунджаас 5 дахин, Ази номхон далайн баруун бүсийн орнууд ба зүүн азийн орнуудын дунджаас 3 дахин өндөр байна (Зураг 8).

Зураг 7. Ходоодны хорт хавдрын өвчлөлийн стандартчилсан түвшин, харьцуулалт



Зураг 8. Ходоодны хорт хавдрын нас баралтын стандартчилсан түвшин, харьцуулалт






### 1.3 Уушгины хорт хавдар:


Монгол улс уушгины хорт хавдрын өвчлөлийн түвшингээр дэлхийн 185 орноос 70-рт эрэмбэлэгдэж дэлхийн дунджаас 1 дахин, Ази номхон далайн баруун бүсийн орнуудын дунджаас 2 дахин, зүүн азийн орнуудын дунджаас 2 дахин бага байна. Хүйсээр ялган харвал эрэгтэй хүйсийн уушигны хорт хавдрын өвчлөлөөр дэлхийн дунджаас өндөр, эмэгтэй хүйсийнх бага байна (Зураг 9).

Уушигны хорт хавдрын нас баралтын түвшингээр дэлхийн 185 орноос 63-рт эрэмбэлэгдэж дэлхийн дундажтай ойролцоо, Ази номхон далайн баруун бүсийн орнуудын дунджаас 1.4 дахин, зүүн азийн орнуудын дунджаас 1.5 дахин бага байна (Зураг 10).

**Зураг 9. Уушгины хорт хавдрын өвчлөлийн стандартчилсан түвшин, харьцуулалт**



**Зураг 10. Уушгины хорт хавдрын нас баралтын стандартчилсан түвшин, харьцуулалт**








## 1.4 Улаанхоолойн хорт хавдар:


Монгол улс улаан хоолойн хорт хавдрын өвчлөлийн түвшингээр дэлхийн 185 орноос 3-рт эрэмбэлэгдэж дэлхийн дунджаас 3 дахин, Ази номхон далайн баруун бүсийн орнуудын дунджаас 2 дахин, зүүн азийн орнуудын дунджаас 2 дахин өндөр байна. Хүйсээр ялган харвал улаан хоолойн хорт хавдрын өвчлөл эрэгтэй хүйсэнд дэлхийн дунджаас 2 дахин өндөр, эмэгтэй хүйсэнд 5 дахин өндөр байна (Зураг 11).

Улаан хоолойн хорт хавдрын нас баралтын түвшингээр дэлхийн 185 орноос 3-рт эрэмбэлэгдэж байгаа ба дэлхийн дунджаас 3 дахин өндөр, Ази номхон далайн баруун бүсийн орнуудын дунджаас 2.5 дахин, зүүн азийн орнуудын дунджаас 2.4 дахин өндөр байна (Зураг 12).

Зураг 11. Улаанхоолойн хорт хавдрын өвчлөлийн стандартчилсан түвшин, харьцуулалт



Зураг 12. Улаанхоолойн хорт хавдрын нас баралтын стандартчилсан түвшин, харьцуулалт






## 1.5 Бүдүүн шулуун гэдэсний хорт хавдар:


Монгол улс бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын өвчлөлийн түвшингээр дэлхийн 185 орноос 130-рт эрэмбэлэгдэж дэлхийн дунджаас 3 дахин бага байна (Зураг 13).

Бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын нас баралтын түвшингээр дэлхийн 185 орноос 154-рт эрэмбэлэгдэж дэлхий, Ази номхон далайн баруун бүсийн орнууд, зүүн азийн орнуудын дунджаас 2 дахин бага байна (Зураг 14).

**Зураг 13. Бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын өвчлөлийн стандартчилсан түвшин, харьцуулалт**



**Зураг 14. Бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын нас баралтын стандартчилсан түвшин, харьцуулалт**





## 1.6 Умайн хүзүү, хөхний хавдар:



Умайн хүзүүний хорт хавдрын өвчлөлийн түвшингээр дэлхийн 185 орноос 53-рт эрэмбэлэгдэж дэлхийн дунджаас 3 дахин, Ази номхон далайн баруун бүсийн орнуудын, зүүн азийн орнуудын дунджаас 1.5 дахин өндөр байна. Харин хөхний хорт хавдрын өвчлөлийн түвшингээр дэлхийн 185 орноос 181-рт эрэмбэлэгдэж дэлхийн дунджаас 3.7 дахин, Ази номхон далайн баруун бүсийн орнуудын дунджаас 1.3 дахин, зүүн азийн орнуудын дунджаас 1.5 дахин бага байна (Зураг 15)

Умайн хүзүүний хорт хавдрын нас баралтын түвшингээр дэлхийн 185 орноос 69-рт эрэмбэлэгдэж дэлхийн дунджаас 1.3 дахин, Ази номхон далайн баруун бүсийн орнууд, зүүн азийн орнуудын дунджаас 2 дахин өндөр байна. Харин хөхний хорт хавдрын нас баралтын түвшингээр дэлхийн 185 орноос 184-рт эрэмбэлэгдэж дэлхийн дунджаас 2.5 дахин, Ази номхон далайн баруун бүсийн орнууд, зүүн азийн орнуудын дунджаас 2 дахин бага байна (Зураг 16).

**Зураг 15. Умайн хүзүү, хөхний хорт хавдрын өвчлөлийн стандартчилсан түвшин, харьцуулалт**

Умайн хүзүүний хорт хавдар



Хөхний хорт хавдар



**Зураг 16. Умайн хүзүү, хөхний хорт хавдрын нас баралтын стандартчилсан түвшин, харьцуулалт**

Умайн хүзүүний хорт хавдар

Хөхний хорт хавдар






## 1.7 Нойр булчирхайн хорт хавдар:


Нойр булчирхайн хорт хавдрын өвчлөлийн түвшингээр дэлхийн 185 орноос 60-рт эрэмбэлэгдэж дэлхийн дундаж, Ази номхон далайн баруун бүсийн орнууд, зүүн азийн орнуудаас өндөр байна (Зураг 17).

Монгол улс нойр булчирхайн хорт хавдрын нас баралтын түвшингээр дэлхийн 185 орноос 62-рт эрэмбэлэгдэж Дэлхийн дундаж, Ази номхон далайн баруун бүсийн орнууд, зүүн азийн орнуудын дунджаас өндөр байна (Зураг 18).

**Зураг 17. Нойр булчирхайн хорт хавдрын өвчлөлийн стандартчилсан түвшин, харьцуулалт**



**Зураг 18. Нойр булчирхайн хорт хавдрын нас баралтын стандартчилсан түвшин, харьцуулалт**







## 1.8 Хүүхдийн хорт хавдар:

Монгол улс дэлхийн 185 орноос хүүхдийн хорт хавдрын өвчлөлийн түвшингээр 151-рт, нас баралтын түвшингээр 113-рт эрэмбэлэгдэж өвчлөлийн түвшингээрээ дэлхийн дундаж, Ази номхон далайн баруун бүсийн орнууд, зүүн азийн орнуудын дунджаас бага, нас баралтын түвшингээр дундаж, Ази номхон далайн баруун бүсийн орнуудаас бага, зүүн азийн орнуудаас өндөр байна (Зураг 19).

Зураг 19. Хүүхдийн хорт хавдрын өвчлөл, нас баралтын стандартчилсан түвшин, харьцуулалт




## Бүлэг 2. ХОРТ ХАВДРЫН ӨВЧЛӨЛ, 2023 ОН



## Бүлэг 2. ХОРТ ХАВДРЫН ӨВЧЛӨЛ, 2023 ОН

### 2.1 Хорт хавдрын өвчлөл, бүтэц

2023 оны хорт хавдрын тайлангаар 7244 хорт хавдрын шинэ өвчлөл оношлогдсоны 3745 (52%) эрэгтэй, 3499 (48%) эмэгтэй байна. Үүний 59.3% нь орон нутагт, 40.7% нь нийслэл хотод оношлогджээ (Хүснэгт 3, Хавсралт 1, Зураг 20).



Зураг 20. Хорт хавдрын өвчлөлийн бүтэц, 2023 он

### Хүснэгт 3. Хорт хавдрын нийт өвчлөл, зонхилох эхний 10 байрлал, хүйс, хувиар

№	Хорт хавдар, бүгд			Эрэгтэй			Эмэгтэй		
	Хорт хавдрын байрлал	Т/ тоо*	%	Хорт хавдрын байрлал	Т/ тоо*	%	Хорт хавдрын байрлал	Т/ тоо*	%
1	Элэг	2373	32.8	Элэг	1338	35.7	Элэг	1035	29.6
2	Ходоод	1259	17.4	Ходоод	860	23.0	Умайн хүзүү	425	12.1
3	Уушиг, гуурсан хоолой	473	6.5	Уушиг, гуурсан хоолой	382	10.2	Ходоод	399	11.4
4	Умайн хүзүү	425	5.9	Улаанхоолой	216	5.8	Хөх	342	9.8
5	Улаанхоолой	357	4.9	Бөөр	150	4.0	Бүдүүн шулуун гэдэс	177	5.1
6	Хөх	344	4.7	Бүдүүн шулуун гэдэс	145	3.9	Бөөр	150	4.3
7	Бүдүүн шулуун гэдэс	322	4.4	Нойр булчирхай	111	3.0	Улаанхоолой	141	4.0
8	Бөөр	300	4.1	Лимфойд лейкеми	66	1.8	Бамбай булчирхай	114	3.3
9	Нойр булчирхай	206	2.8	Тархи мэдрэл	63	1.7	Өндгөвч	109	3.1
10	Бусад байрлал	1185	16.5	Бусад байрлал	414	10.9	Бусад байрлал	607	17.3
		7244			3745			3499	


2023 оны хорт хавдрын өвчлөлийн бүтцийг хүйсэнд нь харьцуулахад эрэгтэйчүүдийн 78.7 хувийг нь элэгний хорт хавдар нэгдүгээрт (35.7%) ходоодны хорт хавдар хоёрдугаарт (23%), уушиг, гуурсан хоолойн хорт хавдар гуравдугаарт (10.2%), улаанхоолойн хорт хавдар дөрөвдүгээрт (5.8%), бөөрний хорт хавдар тавдугаарт (4%), эмэгтэйчүүдийн 68 хувийг элэгний хорт хавдар нэгдүгээрт (29.6%), умайн хүзүүний хорт хавдар хоёрдугаарт (12.1%), ходоодны хорт хавдар гуравдугаарт (11.4%), хөхний хорт хавдар дөрөвдүгээрт (9.8%), бүдүүн шулуун гэдэсний хорт хавдар тавдугаарт (5.1%)-ийг тус тус эзэлж байна.

## 2.2 Хорт хавдрын өвчлөлийн үндсэн үзүүлэлт

### 2.2.1 Хорт хавдрын өвчлөлийн түвшин (Crude rate)-ӨТ

Нийт хорт хавдрын өвчлөлийн түвшин (ӨТ) 100 000 хүн амд 214.1 тохиолдол ногдож байгаа ба энэ үзүүлэлт эрэгтэйчүүдэд 224.7, эмэгтэйчүүдэд 203.9 байна. Элэгний хавдрын өвчлөлийн түвшин эрэгтэй, эмэгтэй хүйсэнд ялгаагүй эхний байранд орж байгаа ба хүйсээр харьцуулахад элэг, ходоод, уушиг гуурсан хоолой, улаан хоолой, давсагны хавдар эрэгтэй хүйсэнд өндөр, харин эмэгтэй хүйсэнд бүдүүн шулуун гэдэс, бамбай булчирхайн хавдрууд өндөр байна (Зураг 21).


Зураг 21. Зонхилох эхний 10 байрлалын хорт хавдар, ӨТ хүйсээр, 100 000 хүн амд



### 2.2.2 Насаар өвөрмөц өвчлөлийн түвшин (Age specific rate)-НӨӨТ

Хорт хавдрын өвчлөл нас ахих тусам нэмэгддэг бөгөөд Зураг 22-т 2023 онд оношлогдсон хавдрын тохиолдлыг насны бүлэг ба насаар харьцуулан харуулав. Хорт хавдрын өвчлөлийн түвшинг насны бүлгээр авч үзвэл нас ахих тусам хорт хавдрын өвчлөлийн түвшин тасралтгүй нэмэгдэн 75-аас дээш насныханд хамгийн өндөр буюу 100 000 хүн амд 2143,4; 100 000 эрэгтэй хүн амд 2671, 100 000 эмэгтэй хүн амд 1844 тохиолдол байна. 2023 онд 10-14 насанд хамгийн цөөн (21), 60-64 насанд хамгийн өндөр (1143) хорт хавдрын тохиолдол бүртгэгджээ. Өвчлөлийн түвшинг хүйсээр ялган харвал 0-24 нас ба 45-аас дээш насны бүлэгт эрэгтэйчүүд хорт хавдарт илүүтэй өртөж байгаа бол 25-44 насанд эмэгтэйчүүд илүүтэй өртөж байна (Зураг 22).

Зураг 22. Насны бүлэг дэхь тохиолдлын тоо, насаар өвөрмөц өвчлөлийн түвшин, хүйсээр, 100 000 хүн амд






Эрэгтэй хүйсэнд зонхилон тохиолдох эхний 5 байрлалын хорт хавдрын өвчлөлийн түвшинг насны бүлэгт харьцуулахад (Зураг 23):

1. Элэгний хавдар 0-4, 10-19 насанд бүртгэгдээгүй, 5-9 насанд цөөн, 20 наснаас эхлэн нас ахих тусам тасралтгүй нэмэгдсээр 75 ба түүнээс дээш насныханд хамгийн өндөр,
2. Ходоодны хавдар 0-19 насныханд бүртгэгдээгүй, 20 наснаас эхлэн нас ахих тусам тасралтгүй нэмэгдсээр 75 ба түүнээс дээш насныханд хамгийн өндөр,
3. Уушигны хавдар 0-24 насанд бүртгэгдээгүй, 25-34 насанд цөөн, 35 наснаас эхлэн нас ахих тусам тасралтгүй нэмэгдсээр 70-74 насныханд хамгийн өндөр,
4. Улаанхоолойн хавдар 0-34 насныханд бүртгэгдээгүй, 35-69 нас хүртэл тасралтгүй нэмэгдэн, 70-74 насанд буурч, 75 ба түүнээс дээш насныханд хамгийн өндөр,
5. Бөөрний хавдар 5-14 насанд бүртгэгдээгүй, 0-4,15-24 насныханд цөөн, 30-59 нас хүртэл нэмэгдээд 60-64 насанд буураад 65 аас хойш тасралтгүй нэмэгдэж байна.


Эмэгтэй хүйсэнд зонхилон тохиолдсон эхний 5 байрлалын хорт хавдрын өвчлөлийн түвшинг насны бүлэгт харьцуулахад (Зураг 23):

1. Элэгний хавдар 0-14 насанд бүртгэгдээгүй,15-34 насанд цөөн, 35 наснаас эхлэн нас ахих тусам тасралтгүй нэмэгдсээр 75 ба түүнээс дээш насныханд хамгийн өндөр,
2. Умайн хүзүүний хавдар 0-19 насныханд бүртгэгдээгүй, 20 наснаас эхлэн нас ахих тусам тасралтгүй нэмэгдсээр 59 нас хүртэл нэмэгдэж, 60 наснаас эхлэн буурсан, 50-54 насныханд хамгийн өндөр
3. Ходоодны хавдар 0-24 насанд бүртгэгдээгүй, 25 наснаас эхлэн нас ахих тусам тасралтгүй нэмэгдсээр 75 ба түүнээс дээш насныханд хамгийн өндөр, ,
4. Хөхний хавдар 0-24 насанд бүртгэгдээгүй, 25-54 нас хүртэл тасралтгүй нэмэгдэн, 55 наснаас хойш -74 насанд буурч, 75 ба түүнээс дээш насныханд хамгийн өндөр,
5. Бүдүүн шулуун гэдэсний хавдар 0-19 насныханд бүртгэгдээгүй, 20 наснаас эхлэн нас ахих тусам аажмаар нэмэгдсээр 75 ба түүнээс дээш насныханд хамгийн өндөр тохиолддог байна.

**Зураг 23. Зонхилох 5 байрлалын хавдрын өвчлөлийн түвшин, насны бүлгээр, хүйсээр**




**Зураг 24. Зонхилох 5 байрлалын хавдрын өвчлөлийн насны бүлэгт эзлэх хувь, эрэгтэй хүйс**



Эрэгтэй хүйсэнд зонхилон тохиолдсон эхний 5 байрлалын хорт хавдрын өвчлөлийн түвшинг насны бүлэгт эзлэх хувийн жингээр харуулбал 0-4, 15-19, 20-24 насанд бөөрний хавдар, 5-9, 45 ба түүнээс дээш насныханд элэгний хавдар, 25-29 насанд уушигны хавдар, 30-39 насанд ходоодны хавдар зонхилон тохиолджээ (Зураг 24).


**Зураг 25. Зонхилох 5 байрлалын хавдрын өвчлөлийн насны бүлэгт эзлэх хувь, эмэгтэй хүйс**



Эмэгтэй хүйсэнд зонхилон тохиолдсон эхний 5 байрлалын хорт хавдрын өвчлөлийн түвшинг насны бүлэгт эзлэх хувийн жингээр харуулбал 20-54 насанд умайн хүзүү, 15-19, 55 ба түүнээс дээш насныханд элэгний хавдар зонхилон тохиолджээ (Зураг 25).

2.2.3 Хорт хавдрын өвчлөлийн стандартчилсан түвшин (Age standardized incidence rate)-ӨСТ

2023 оны байдлаар Монгол улсад бүртгэгдсэн нийт хорт хавдрын тохиолдлын тоог дэлхийн стандарт хүн амтай харьцуулан тооцоход 100 000 хүн амд 243.6 тохиолдол ногдож байгаа ба энэ үзүүлэлт эрэгтэйчүүдэд 297.8, эмэгтэйчүүдэд 206.3 байна (Хавсралт 1, Зураг 26).



Зураг 26. Өвчлөлийн түвшин, өвчлөлийн стандартчилсан түвшин, 100000 хүн амд, хүйсээр

## 2.3 Хорт хавдрын өвчлөл, TNM үе шатаар

Олон улсад цусны, булчирхай, тархи, мэдрэлийн гаралтай хорт хавдраас бусад байрлалын хорт хавдрыг TNM ангилалыг баримтлан үе шатыг тогтоодог. TNM ангилалд хамаарах хорт хавдрын үе шатыг байрангаас 2 үе шатыг эрт үеийн хорт хавдар, 3 ба 4 үе шатыг хожуу үеийн хавдар хэмээж хувийг тооцсон.


2023 онд бүртгэгдсэн зонхилох 10 байрлалын хавдрын 34.6% нь эрт үе шатандаа, 65.4% нь хожуу үе шатандаа оношлогджээ (Хүснэгт 4).

Зонхилох байрлалын хорт хавдруудаас уушиг гуурсан хоолойн (89.4%), улаан хоолойн (74.2%), элэг (70.1%), хорт хавдрууд ихэвчлэн хожуу үе шатандаа оношлогдож байгаа бол хөх (66%), умайн хүзүүний (52.9%) хорт хавдрууд харьцангуй эрт үе шатандаа оношлогджээ (Зураг 27, хүснэгт 4).

Хүснэгт 4. Хорт хавдрын оношлогдох үеийн үе шат (TNM ангилал), хувиар

Хавдрын байрлал	Байран	I үе	II үе	III үе	IV үе	эрт үе	хожуу үе
Элэг	0.0	5.0	24.9	38.1	32.0	29.9	70.1
Ходоод	0.8	12.0	20.3	40.2	26.8	33	67
Уушиг, гуурсан хоолой	0.0	1.9	8.7	40.2	49.3	10.6	89.4
Улаанхоолой	0.0	7.8	17.9	41.7	32.5	25.8	74.2
Умайн хүзүү	9.6	12.9	30.4	37.9	9.2	52.9	47.1
Хөх	2.6	17.4	45.9	24.4	9.6	66	34
Бүдүүн шулуун гэдэс	0.0	2.0	24.3	34.4	39.3	26.3	73.7
Бөөр	0.0	44.1	23.4	25.4	7.1	67.5	32.5
Нойр булчирхай	0.0	1.0	14.1	37.9	47.1	15	85
Бүгд	0.9	9.8	23.9	37.1	28.4	34.6	65.4


**Зураг 27. Зонхилох хорт хавдрын оношлогдох үеийн үе шат (эрт ба хожуу), хувиар**



## 2.4 Хорт хавдрын өвчлөлийн түвшин, аймгуудаар

2023 онд хорт хавдрын өвчлөлийн улсын дундаж түвшин 214.1 тохиолдол ногдож Булган аймаг өвчлөлийн түвшингээр хамгийн өндөр (379.8), Баян-Өлгий аймаг бага (154.1) үзүүлэлттэй, 15 аймгийн өвчлөлийн түвшин улсын дунджаас өндөр байна (Зураг 28).

**Зураг 28. Хорт хавдрын өвчлөлийн түвшин, 100000 хүн амд, аймаг бүсээр**



Монгол улсын газар зүйн бүс нутгаар хорт хавдрын өвчлөлийг улсын дундажтай харьцуулахад баруун, зүүн, хангайн, төвийн бүсүүд улсын дунджаас өндөр, Улаанбаатар хотод бага үзүүлэлттэй байна. (Хавсралт 5, Зураг 28).

## 2.5 Зонхилох байрлалын хорт хавдар

Нийт хорт хавдрын шинэ өвчлөлийг 2022 онтой харьцуулахад 432 тохиолдол буюу элэг (3.8%), ходоод (6.6%), умайн хүзүү (33.6%), улаан хоолой (4.3%), хөх (21.5%), бүдүүн шулуун гэдэс (5.2%), бөөр (4.1%) тус тус нэмэгдсэн бол уушиг гуурсан хоолой (9.2%), нойр булчирхай (8%), бусад байрлалын хавдар (0.6%) буурсан үзүүлэлттэй байна (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Зонхилох байрлалын хорт хавдрын өвчлөлийн харьцуулсан үзүүлэлт


Хорт хавдар, төрөл	Бодит тоо (эзлэх хувь)		Өөрчлөлт зөрүү	
	2022	2023	Нэмэгдсэн тоо, %	Буурсан тоо, %
Элэг	2286(33.2)	2373 (32.8)	87(3.8)	
Ходоод	1181(17.2)	1259 (17.4)	78(6.6)	
Уушиг, гуурсан хоолой	521(7.6)	473 (6.5)		48(9.2)
Умайн хүзүү	318(4.6)	425 (5.9)	107(33.6)	
Улаан хоолой	342(5)	357(4.9)	15(4.3)	
Хөх	283(4.1)	344(4.7)	61(21.5)	
Бүдүүн шулуун гэдэс	306(4.4)	322 (4.4)	16(5.2)	
Бөөр	232(3.4)	300 (4.1)	68(9.3)	
Нойр булчирхай	224(3.3)	206 (2.8)		18(8)
Бусад хавдар	1192(17.3)	1185 (16.4)		7(0.6)
<b>Бүгд</b>	<b>6885</b>	<b>7244</b>	<b>432</b>	<b>73</b>

### 2.5.1 Элэгний хорт хавдар



Элэгний хорт хавдрын 2373 шинэ тохиолдол бүртгэгдсэний 1338 (56%) эрэгтэй, 1035(44%) эмэгтэйчүүд өвчилжээ. Элэгний хорт хавдрын өвчлөл 100 000 хүн амд 70.2 тохиолдол, эрэгтэй хүйсийн 100 000 хүн амд 80.3 тохиолдол, эмэгтэй хүйсийн 100 000 хүн амд 60.3 тохиолдол байна. Элэгний хорт хавдрын тархалтыг Монгол улсын газар зүйн бүс нутгаар харьцуулан үзэхэд Зүүн бүсийн аймгууд улсын дунджаас өндөр өвчлөлтэй эрэгтэй 100 000 хүн амд 124.9 тохиолдол, эмэгтэй 100 000 хүн амд 89.7 тохиолдол оногдож байна (Хавсралт 6). Аймгуудаас 100 000 хүн амд харьцуулсан үзүүлэлтээр Булган 135.9 тохиолдол, Хэнтий 123.7 тохиолдол, Архангай 112.2 тохиолдлуудаар тэргүүлж байгаа ба Орхон, Дорноговь, Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Баян-Өлгий аймгууд, Улаанбаатар хотод улсын дунджаас бага тохиолдож байна (Зураг 29).

**Зураг 29. Элэгний хорт хавдрын өвчлөлийн түвшин, 100000 хүн амд, аймаг бүсээр**




### 2.5.2 Ходоодны хорт хавдар



Ходоодны хорт хавдрын 1259 шинэ тохиолдол бүртгэгдсэний 860 (68%) эрэгтэй, 399 (32%) эмэгтэйчүүд өвчилжээ. Ходоодны хорт хавдрын өвчлөл 100 000 хүн амд 37.2 тохиолдол, эрэгтэй хүйсийн 100 000 хүн амд 51.6 тохиолдол, эмэгтэй хүйсийн 100 000 хүн амд 23.3 тохиолдол байна. Ходоодны хорт хавдрын тархалтыг Монгол улсын газар зүйн бүс нутгаар харьцуулан үзэхэд Улаанбаатар хот, Төвийн бүсэд улсын дунджаас бага, Баруун, Зүүн, Хангайн бүсэд улсын дунджаас өндөр байв (Хавсралт 7). Аймгуудаас 100 000 хүн амд харьцуулсан үзүүлэлтээр Увс 73.9 тохиолдол, Булган 60.6 тохиолдол, Завхан 56.5 тохиолдлуудаар тэргүүлж байгаа ба Баян-Өлгий, Дорноговь, Сүхбаатар, Баянхонгор, Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр аймгууд, Улаанбаатар хотод улсын дунджаас бага тохиолдож байна (Зураг 30).

**Зураг 30. Ходоодны хорт хавдрын өвчлөлийн түвшин, 100000 хүн амд, аймаг бүсээр**




2.5.3 Уушгины хорт хавдар



Уушгины хорт хавдрын 473 шинэ тохиолдол бүртгэгдсэний 382 (80%) эрэгтэй, 91(20%) эмэгтэйчүүд өвчилжээ. Уушгины хорт хавдрын өвчлөл 100 000 хүн амд 14 тохиолдол, эрэгтэй хүйсийн 100 000 хүн амд 22.9 тохиолдол, эмэгтэй хүйсийн 100 000 хүн амд 5.3 тохиолдол байна. Уушгины хорт хавдрын тархалтыг Монгол улсын газар зүйн бүс нутгаар харьцуулан үзэхэд улсын дунджаас Баруун бүс, Улаанбаатар хотод бага, Зүүн, Төвийн Хангайн бүсүүдэд өндөр байжээ (Хавсралт 8). Аймгуудаас 100 000 хүн амд харьцуулсан үзүүлэлтээр Булган 29.5 тохиолдол, Дорноговь 22.3 тохиолдол, Увс 22.3 тохиолдлуудаар тэргүүлж байгаа ба Говьсүмбэр, Завхан, Өвөрхангай, Дархан-Уул, Баянхонгор, Өмнөговь, Баян-Өлгий аймгууд, Улаанбаатар хотод улсын дунджаас бага тохиолдож байна (Зураг 31).

Зураг 31. Уушгины хорт хавдрын өвчлөлийн түвшин, 100000 хүн амд, аймаг бүсээр



2.5.4 Улаанхоолойн хорт хавдар




Улаанхоолойн хорт хавдрын 357 шинэ тохиолдол бүртгэгдсэний 216(60%) эрэгтэй, 141(40%) эмэгтэйчүүд өвчилжээ. Улаанхоолойн хорт хавдрын өвчлөл 100 000 хүн амд 10.6 тохиолдол, эрэгтэй хүйсийн 100 000 хүн амд 13 тохиолдол, эмэгтэй хүйсийн 100 000 хүн амд 8.2 тохиолдол байна.

Улаанхоолойн хорт хавдрын тархалтыг Монгол улсын газар зүйн бүс нутгаар харьцуулан үзэхэд улсын дунджаас зүүн бүс, Улаанбаатар хотод бага, баруун, Хангайн, Төвийн бүсүүдэд өндөр байжээ (Хавсралт 9).

Аймгуудаас 100 000 хүн амд харьцуулсан үзүүлэлтээр Увс 30.5 тохиолдол, Өвөрхангай 24.9 тохиолдол, Баян-Өлгий 18.2 тохиолдлуудаар тэргүүлж байгаа ба Хэнтий, Дундговь, Говьсүмбэр, Баянхонгор, Дорноговь аймгууд, Улаанбаатар хотод улсын дунджаас бага тохиолдож байна (Зураг 32).

**Зураг 32. Улаанхоолойн хорт хавдрын өвчлөлийн түвшин, 100000 хүн амд, аймаг бүсээр**




**2.5.5 Бүдүүн шулуун гэдэсний хорт хавдар**



Бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын 322 шинэ тохиолдол бүртгэгдсэний 145(45%) эрэгтэй, 177(55%) эмэгтэйчүүд өвчилжээ. Бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын өвчлөл 100 000 хүн амд 9.5 тохиолдол, эрэгтэй хүйсийн 100 000 хүн амд 8.7 тохиолдол, эмэгтэй хүйсийн 100 000 хүн амд 10.3 тохиолдол байна. Бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын тархалтыг Монгол улсын газар зүйн бүс нутгаар харьцуулан үзэхэд Баруун, Хангайн, бүсийн аймгуудад улсын дунджаас бага, Зүүн, төвийн бүс ба Улаанбаатар хотод өвчлөл өндөр байжээ (Хавсралт 10). Аймгуудаас 100 000 хүн амд харьцуулсан үзүүлэлтээр Говьсүмбэр 22.1 тохиолдол, Хэнтий 20.2 тохиолдол, Сэлэнгэ 14.0 тохиолдлуудаар тэргүүлж байгаа ба, Өвөрхангай, Сүхбаатар, Ховд, Дорнод, Говь-Алтай, Архангай, Төв, Баян-Өлгий, Баянхонгор, Хөвсгөл аймгуудад улсын дунджаас бага тохиолдож байна (Зураг 33).

**Зураг 33. Бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын өвчлөлийн түвшин, 100000 хүн амд, аймаг бүсээр**






2.5.6 Умайн хүзүүний хорт хавдар



Умайн хүзүүний хорт хавдрын 425 шинэ тохиолдол бүртгэгдсэн байна. Умайн хүзүүний хорт хавдрын өвчлөл нийт 100 000 хүн амд 12.6 тохиолдол байгаа бол эмэгтэй хүйсийн 100 000 хүн амд 24.8 тохиолдол байна. Умайн хүзүүний хорт хавдрын тархалтыг Монгол улсын газар зүйн бүс нутгаар эмэгтэй хүн амд харьцуулан үзэхэд Зүүн, Төв, Хангайн, бүсийн аймгуудад улсын дунджаас өндөр, Баруун бүс ба Улаанбаатар хотод өвчлөл бага байжээ (Хавсралт 11). Аймгуудаас 100 000 эмэгтэй хүн амд харьцуулсан үзүүлэлтээр Булган 63.5 тохиолдол, Дархан-уул 56.5 тохиолдол, Говьсүмбэр 55.1 тохиолдлуудаар тэргүүлж байгаа ба Ховд, Сэлэнгэ, Сүхбаатар, Говь-Алтай, Архангай, Хөвсгөл, Дундговь, Увс, Завхан, Баян-Өлгий аймгуудад улсын дунджаас бага тохиолдож байна (Зураг 34).

Зураг 34. Умайн хүзүүний хорт хавдрын өвчлөлийн түвшин, 100000 эмэгтэй хүн амд, аймаг бүсээр




2.5.7 Хөхний хорт хавдар



